



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 3.4.2, 3.4.17 дах заалт, "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/26 дугаар тушаалын 3.1.1, 4.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн богино хугацааны сургалт зохион байгуулах журам"-ыг нэгдүгээр, "Сургалтын хөтөлбөрийн загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга (Д.Ичинхорлоо) -д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын албаны дарга (Ш.Алтанцэцэг)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 76 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 03 дугаар сарын 25.-ны
өдрийн 11:00 дугаар тушаалын хавсралт

УХАД455 9086321
**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ БАГЦ ЦАГИЙН БОГИНО ХУГАЦААНЫ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар багц цагийн богино хугацааны сургалтын зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох” журмын 8 дугаар бүлэгт заасны дагуу шалгуур хангаж эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “төв” гэх/-өөс зөвшөөрөл авсан байгууллага тасралтгүй сургалтыг зохион байгуулна.
- 1.3 Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрлийг тухай бүр удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж 2 жилийн хугацаатай олгоно.
- 1.4 Тасралтгүй сургалт эрхлэх байгууллага нь багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн салбар зөвлөлөөр батлуулж, төвөөр хянуулсанаар сургалтыг зөвшөөрөгдсөнд тооцно.
- 1.5 Тасралтгүй сургалтын үйл ажиллагааг энэхүү журмаас гадна эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан бусад холбогдох хууль, тогтоомжийг баримтлан зохицуулна.

Хоёр. Сургалтын удирдлага, зохион байгуулалт

- 2.1 Багц цагийн сургалт зохион байгуулах чиглэлээр төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 2.1.1 Шалгуур хангасан байгууллагын сургалт эрхлэх хүсэлтийг тухай бүрт хүлээн авч төвийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэх;
 - 2.1.2 Сургалт эрхлэх байгууллагаас ирүүлсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн оны нэгдүгээр сард багтаан хүлээн авч шийдвэрлэх;
 - 2.1.3 Батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тухайн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөлтийг цахим хуудсанд байршуулах;
 - 2.1.4 Засгийн газрын бодлого, чиглэл болон цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой зохион байгуулагдах сургалтын хөтөлбөрийг тухай бүр хүлээн авч шийдвэрлэх;
 - 2.1.5 Сургалт эрхлэх байгууллагын зохион байгуулж буй сургалтын үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж, багц цагийг баталгаажуулах;
 - 2.1.6 Сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж хүргүүлэх;

- 2.1.7 Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагын сургалтын үйл ажиллагааны жилийн тайлан, үнэлгээний дунг төвийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж зөвшөөрлийг сунгах асуудлыг шийдвэрлэх;
 - 2.1.8 Сургалт эрхлэх байгууллага болон суралцагсдаас ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх;
- 2.2 Тасралтгүй сургалт эрхлэх байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
Үүнд:
 - 2.2.1 Тухайн жилд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг мэргэжлийн салбар зөвлөлөөр батлуулсан хөтөлбөрийн хамт жил бүрийн нэгдүгээр сард багтаан төвд хүргүүлэх;
 - 2.2.2 Төвөөс зөвшөөрсөн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулах;
 - 2.2.2.1 Батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын зарыг “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” /цаашид “нэгдсэн бүртгэлийн сан” гэх/-д байршуулж, бүртгэлийг хийх;
 - 2.2.2.2 Төлөвлөсөн сургалт эхлэхээс өмнө сэдэвчилсэн сургалтын агуулгын хүрээнд боловсруулсан 10-15 сорилыг нэгдсэн бүртгэлийн санд байршуулах;
 - 2.2.2.3 Сургалт бүрийн төгсгөлд суралцагсдын ирцийг нэгдсэн бүртгэлийн сан програмаар бүртгэх;
 - 2.2.2.4 Сургалтын өмнөх болон дараах сорилыг нэгдсэн бүртгэлийн сан програмаар авах;
 - 2.2.2.5 Сургалтын дараах сорилоор 70-с доош үнэлэгдсэн тохиолдолд багц цагийг олгохгүй байх;
 - 2.2.2.6 Сургалтын тайланг сургалт зохион байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан төвд хүргүүлэх;
 - 2.2.3 Сургалтад оролцогчдын бүртгэл, тайлангийн үнэн зөв байдлыг сургалт эрхлэх байгууллага бүрэн хариуцах;
 - 2.2.4 Сургалт эрхлэх хугацааны үйл ажиллагааны тайланг зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ажлын албанд ирүүлэх;
 - 2.2.5 Цахим сургалт зохион байгуулах тохиолдолд төвийн “Цахим сургалтын нэгж”-тэй гэрээ байгуулж, хамтарч ажиллах;

Гурав. Багц цагийн богино хугацааны сургалтын хэлбэр, хугацаа

- 3.1 Багц цагийн богино хугацааны сургалтыг эмнэлзүйн болон эмнэлзүйн бус чиглэлээр танхим, цахим мөн хосолсон хэлбэрээр зохион байгуулна.
 - 3.1.1 Танхимиын сургалтыг лекц, семинар, хурал болон зөвлөгөөн зэрэг хэлбэрээр зохион байгуулна.
 - 3.1.1.1 Сургалтын хугацаа нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох” журмын 2.6.2-т заасны дагуу байна.
 - 3.1.1.2 Сургалтын багц цагийг Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд

мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох" журмын 6.1-д заасны дагуу тооцно.

3.1.2 Цахим сургалтыг аудио, видео, телемедицин, интерактив, цахимаар шууд холбогдох зэрэг хэлбэрээр зохион байгуулна.

3.1.2.1 Тухайн цахим сургалтын хичээлийг байршуулсан, шинэчилсэн, хүчинтэй байх хугацааг тодорхой тусгана.

3.1.2.2 Эмнэлгийн мэргэжилтэнд цахим сургалтын эрх нээгдсэн тохиолдолд 30 хоногийн хугацаанд цуврал хичээлийг судалж дуусгасан байх тохиргоотой байна.

3.1.2.3 Нэг удаагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 20 минутаас доошгүй байх ба нийт 4 цагаас багагүй агуулгын багтаамжтай байна.

3.1.2.4 Цахим сургалтын хичээлийн агуулгыг 2 жилд нэг удаа шинэчилнэ.

3.1.3 Танхим болон цахим сургалтыг хослуулан зохион байгуулж болно.

3.2 Цахим сургалтын хичээлд тавигдах шаардлага.

3.2.1 Цахим сургалтын хөтөлбөрт дараах мэдээллийг тусгана:

3.2.1.1 Сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтний зорилтот бүлэг

3.2.1.2 Хичээлийн зорилго, зорилт, товч агуулга

3.2.1.3 Сургалт зохион байгуулах байгууллага, сургалтын арга зүй

3.2.1.4 Сургалт явагдах хугацаа, давтамж

3.2.1.5 Тухайн хичээлийн цагийн багтаамж, олгох багц цаг

3.2.1.6 Тухайн хичээлд хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоо

3.2.1.7 Хичээл бэлтгэсэн багшийн мэдээлэл

3.2.1.8 Хичээл заах багшийн мэдээлэл

3.2.1.9 Хичээл төлбөртэй эсэх, төлбөрийн хэмжээ

3.2.1.10 Сургалтад оролцогчдын мэдлэг, чадварыг үнэлэх асуулт, хариулт зэрэг сургалтыг үнэлэх, дүгнэх арга хэлбэр

3.2.1.11 Тухайн хичээлээр нэмэлт мэдээлэл судлах эх үүсвэр

3.2.2 Видео хичээлд тавигдах шаардлага:

3.2.2.1 Тухайн хичээлийн сэдэвтэй тохирч байх;

3.2.2.2 Нягтрал 720 буюу түүнээс дээш, чанартай дүрс хэрэглэх;

3.2.2.3 Суралцагсдад сонирхолтой, утга илэрхийлэх дүрс тодорхой байх;

3.2.2.4 Видео хичээлийн агуулгад тухайн хичээлийн сүүлийн үеийн мэдээлэл, онол болон тэдгээрийн ажлын байрандах хэрэглээ, тухайн салбарын мэргэжилтэн, эрдэмтдийн болон өөрийн байр суурийг тусгаж, нэмэлт материал болон холбогдох эх сурвалжийг дурдсан байх;

3.2.2.5 Видео хичээл нь арга зүйн талаасаа сэдэлжүүлэх, зааварчлах, таниулах, тайлбарлах, харьцуулах, маргаантай асуудал дэвшигүүлэх, дүн шинжилгээ хийх байдлаар боловсруулалт хийгдсэн байх;

3.2.3 Дуу бичлэгт тавигдах шаардлага:

- 3.2.3.1 Хэт өндөр давтамжгүй байх;
- 3.2.3.2 Дууны давтамж нэг хэвийн биш байх;
- 3.2.3.3 Энгийн ойлгомжтой байх;
- 3.2.3.4 Чухал хэсгүүдийг онцолж тайлбарласан байх;
- 3.2.3.5 Гадны нэмэлт шуугиангүй, HD буюу өндөр нягтралтай байх;

- 3.2.4 Цахим хэлэлцүүлэг зохион байгуулахад тавигдах шаардлага:
 - 3.2.4.1 Мэдлэгээ бататгахаас гадна асуудлыг олж харах, тухайн асуудалд оновчтой, ойлгомжтой хариулт авахад нь туслах зорилгыг агуулах;
 - 3.2.4.2 Асуулт асуух, хариулах, санаа бодлоо илэрхийлэх, асуудалд дүн шинжилгээ хийх зэрэг бүтээлчээр мэтгэлцэх арга хэлбэрийг гол болгосон байх;
 - 3.2.4.3 Тухайн сонгосон хичээлийн дараа сургалт зохион байгуулсан багш тодорхой хугацаа тогтоож, сургалтад оролцогчдод хугацааг урьдчилан мэдэгдэж явуулах;

3.2.5 Бие даан гүйцэтгэх ажил:

- 3.2.5.1 Бие даан гүйцэтгэх даалгавар нь тухайн хичээлийн онолын ойлголтыг практик үйл ажиллагаатай уялдуулсан байна.
- 3.2.5.2 Бие даалтын ажлын агуулга нь тодорхой, хичээлийн үндсэн болон нэмэлт материалтай ажиллаж мэдлэгээ бататгаж, аливаа асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, өөрийн шийдэл, хувилбарыг дэвшүүлэх, батлах, нотлох, зэргээр суралцагсдын бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна.
- 3.2.5.3 Бие даан гүйцэтгэх (дасгал, даалгавар, сорил, бие даалт, судалгаа) ажлын хугацаа, онолын тайлбар, жишээ, даалгавар зэргийг тодорхой зааж өгсөн байна.
- 3.2.5.4 Цахим хичээлийн бие даан гүйцэтгэх ажилд даалгавар илгээх, үнэлүүлэх, асуулт, хариулт зэрэг багш сургалтад оролцогчдын эргэх холбоотой байх нөхцөлийг хангасан байна.


Дөрөв. Багц цагийн богино хугацааны сургалтын баталгаажуулалт

- 4.1 Тухайн сургалтын багц цаг нь ирцийн бүртгэл, хичээлийн өмнөх болон дараах сорилын дүнгээр цахим програмд баталгаажна.
- 4.2 Суралцагч нь багц цагийн баталгаажилтын мэдээллийг лавлагаа байдлаар програмаас хэвлэн авах боломжтой.

Тав. Хариуцлага

- 5.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын
2022 оны 03 дугаар сарын 25.-ны
өдрийн 11:25.. дугаар тушаалын хавсралт



ТУХАЙН СУРГАЛТЫН СЭДЭВ

Хөтөлбөр боловсруулсан: Гарын үсэг Овог нэр /эрдмийн цол, мэргэжлийн
зэрэг/

Хөтөлбөр хянасан: Гарын үсэг, тамга, тэмдэг Овог, нэр /Сургалт эрхлэх
байгууллагын дарга,
захирал/

Хөтөлбөр баталсан: Гарын үсэг, тамга, тэмдэг Овог нэр, /Мэргэжлийн салбар
зөвлөлийн дарга/

Сургалт зохион байгуулагч: Гарын үсэг Овог нэр /Албан тушаал, холбогдох
утасны дугаар/

Сургалт үргэлжлэх хугацаа: /онол, дадлагын цагийг тодорхой тусгах/

Сургалт зохион байгуулах байршил:

Олгох багц цаг:

Нэг удаагийн сургалтад хамрагдах хүний тоо:

Жилд зохион байгуулах сургалтын нийт тоо: /Батлагдсан хөтөлбөрөөр хэдэн
удаа сургалт зохион байгуулах
тоо/